



**МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

БҮХ НИЙТИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ҮҮРГИЙН САНГИЙН ЕРӨНХИЙ
МЕНЕЖЕР Ц.ЖАДАМБАА ТАНАА

2015.04.06 № 1/31

Зөрчлийг арилгах тухай

Үндэсний аудитын газрын 2015 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2014 оны санхүүгийн тайланд аудит хийхэд дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Тус сан нь Монгол Улсын 2014 оны төсвийн тухай хуулийн дагуу харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч 543 байгууллагаас улсын төсөвт 3,927,0 сая төгрөг төвлөрүүлэхээс 3,214,5 сая төгрөгийг төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 712,0 сая төгрөгөөр буюу 18,2 хувиар тасалдуулсан байна.

Энэ нь харилцаа холбооны тусгай зөвшөөрөл эзэмшигч байгууллагуудын төлбөрийн чадвар муудаж, төлбөр төлөх хугацаа хойшлогдсон, тайлант оны 4 дүгээр улирлын төлбөр нь дараа онд дамжин төлөгддөг зарим тусгай зөвшөөрөл эзэмшигч нь давхар бизнес эрхэлдэгээс нийт борлуулалтын орлогоос харилцаа холбооны орлогыг салгаж татвар төлөх хүсэлт ирүүлдэг зэрэгтэй холбоотой байна. 2014 оны жилийн эцсийн байдлаар 2010-2014 онуудад үүссэн 107 байгууллагын 624,5 сая төгрөгийн хуримтлагдсан авлага үүссэн байна.

Энэ нь Засгийн газрын 2009 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Бүх нийтийн үйлчилгээний үүргийн санг бүрдүүлэх, зарцуулах журам"-д заасан сангийн орлогыг бүрдүүлэхтэй холбоотойгоор БНҮҮС, ХХЗХ-ны хоорондын ажлын уялдаа, холбоог хэрхэн зохицуулах, аж ахуйн нэгжүүдийн тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж олсон орлогыг татвар ногдох орлогоос яаж салган тооцох зэрэг асуудлыг тусгайлан заагаагүй, тайлант оны татварын орлого нь дараа онд дамжин тооцогддог зэргийг тодорхой тусгаагүйтэй холбоотой байна.

2. Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн 2014 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар гарсан дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл өмнөх оноос 2,119,3 сая төгрөгөөр нэмэгдэж, 2014 оны жилийн эцэст 13,417,4 сая төгрөгт хүрсэн бөгөөд үүнийг дотор нь задалж үзвэл нь 5,393,7 сая төгрөгийн хэрэгжиж дууссан ажил үйлчилгээ, сургалтын төсөл, 3,634,7 сая төгрөгийн гэрээний хугацаа болоогүй төсөл, 4,388,8 сая төгрөгийн хэрэгжиж дууссан боловч хаана шилжиж бүртгэгдэхийг эрх зүйн хувьд шийдвэрлэж чадаагүй хөрөнгө байна.

Энэ нь төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон хөрөнгийг төрийн өмчид хэрхэн бүртгэх, үзүүлсэн ажил, үйлчилгээг хэрхэн зардалд бүртгэх

асуудлыг эрх зүйн хувьд заагаагүйгээс олон жил шийдвэрлэгдэхгүй дуусаагүй үйлдвэрлэл дансны үлдэгдэл хуримтлагдсан байна.

Иймд дээр дурдсан 2 асуудлаар эрх зүйн акт гаргуулах талаар холбогдох байгууллагад хандаж шийдвэрлүүлэх шаардлагатай байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн дээр дурдсан зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2015 оны 10 дугаар сарын 01-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус сангийн Ерөнхий менежер Ц.Жадамбаа, ажлын албаны дарга Б.Буян-өлзий, Ахлах нягтлан бодогч Э. Хонгорзул нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА БИЧСЭН:

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН
АХЛАХ АУДИТОР



Ц.ЦЭРЭНХҮҮ